

вэб сайтаас авсан текст: <https://doucovani.edu.cz/pro-rodice>

вэб сайт дээр байгаа мэдээлэл: <https://doucovani.edu.cz/for-parents>

ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН

МЭДЭЭЛЭЛ, ҮҮНИЙГ ЭЦЭГ ЭХЧҮҮДТЭЙ ХУВААЛЦАХ НЬ ЗҮЙТЭЙ

Хичээл давтах сургалттай үндэсний төлөвлөгөө гэж юу вэ?

Боловсрол, залуучууд ба спортын яамнаас COVID-19 цар тахлын өвчин туссан үед сургуулиуд дээр бүтэн цагаар багшлахгүй байх үеэс гарсан сөрөг үр дагаврыг бууруулах зорилгоор **Хичээл давтах сургалттай үндэсний төлөвлөгөө** боловсруулсан. Энэ нь нэн түрүүнд сургуульдаа муу үр дүнтэй сурдаг, бас онцгой тохиолдолд нь сургуулиа орхих эрсдэлтэй сурагчдад зориулагдсан юм. Эдгээр сурагчдын сургалтын үр дүн ноцтойгоор муудсан байх үед энэ төлөвлөгөөнд хамаарч болно.

Хичээл давтах эсвэл нэмэлт боловсрол нь манай сургуульд ч гэсэн хамаарах уу?

Энэхүү төлөвлөгөө нь БНЧУ-ын бүх суурь сургууль, дунд сургууль ба консерваториудад зориулж, ганцаарчилсан болон бүлгийн хичээл давтах сургалтыг хэрэгжүүлэхэд эсвэл сурагчдад зориулсан нэмэлт боловсрол олгоход нь тус тус дэмжлэг үзүүлэх болно. Боловсрол, залуучууд ба спортын яамнаас 2021 оны 11-р сарын 5-аас 16-ны хооронд хэрэгжүүлсэн ээлжит бус судалгааг явуулж, сургуулиас ирсэн мэдээллийг үндэслэж, хичээл давтах шаардлагатай сурагчдын тоо болон тус сургуулийн сургалтын муу үр дүнтэй сурдаг сурагчдын тоог харгалзан, математик загвар боловсруулсны дагуу сургуулиудад нь санхүүгийн хэрэгслүүдийг тарааж өгсөн. Энэ загвар нь сурагчдын тоог гурван бүлгэм болгож хуваана, тэгэхдээ сургалтын муу үр дүн ба хичээлдээ хоцорч байгаа уруудах үзүүлэлтийг анхаарна. Хичээл давтах сургалтын дэмжлэг нь эхний үе шатанд 2021 оны 9-р сарын 1-ээс 12-р сарын 31-ний хооронд явагдсан бөгөөд 2022/2023 хичээлийн жилийн эцэс хүртэл үргэлжлэх төлөвлөгөөтэй.

Миний хүүхдэд хэн хичээл давтах сургалт явуулах вэ?

Хичээл давтах сургалт эсвэл нэмэлт боловсрол олгоход тухайн сургуулийн эсвэл зэргэлдээ сургуулийн багш нар, туслах багш нар, оюутнууд эсвэл тэтгэвэрт гарсан багш нар нэмэлт сургалтыг явуулах болно. Түүнээс гадна Таны орчин тойронд ажилладаг ашгийн бус байгууллагуудын сайн дурын ажилтнууд ч гэсэн мөн нэмэлт хичээл заах боломжтой. Тэд дараа нь сургуулийн ажилтан нь болж, дээд талд нь урамшуулал 250 крон/цаг авах эрхтэй болно. Хичээл давтах эсвэл нэмэлт сургалт нь ялангуяа биечлэн хувь хүнтэй явагдах ёстой бөгөөд үндсэн хичээлүүдэд нь анхаарлаа төвлөрүүлэх ёстой.

Хичээл давтах эсвэл нэмэлт боловсрол олгох нь заавал байх ёстой юу?

Сургууль нь шалгуур үзүүлэлтийг ашигласны дагуу сурагчдад хичээл давтах эсвэл нэмэлт боловсрол олгох тухай (Та тэдгээрийг [ZDE/ЭНДЭЭС/олж](#) болно) шийдвэрлэдэг. Хичээл давтах эсвэл нэмэлт сургалт явуулах нь сургуульд заавал хамрагдах ёстой боловсролын

бүрэлдэхүүн хэсэг биш бөгөөд юуны өмнө Таны сургуультай хэлэлцэж тохиролцсоноос хамаардаг. Энэ бол маш том боломж болох бөгөөд үүнийг ашиглахгүй өнгөрч байвал, их харамсалтай юм, энэ нь хүүхдийг "айлгах зүйл" биш болно. Хүн бүр бүх зүйлийг төгс мэддэггүй, сургуулийн бүх хичээлийг сонирхохгүй байх нь хэвийн үзэгдэл юм. Хүн бүр ямар нэг зүйлийг ойлгохгүй байж болно, юмыг шууд ухаарахгүй байх, мэдэхгүй байж болно. Тийм учраас ийм тохиолдолд туслах хүмүүс байдаг. Хэрэв Та энэ хичээл давтах хөтөлбөрийн хүрээнд нь хичээл давтах эсвэл нэмэлт боловсролд сонирхож байвал, хүүхдүүдэд нэмэлт сургалт явуулах талаар сургуулийн удирдлага эсвэл тухайн ангийн багштай зөвлөлдөх боломжтой.

Хичээл давтах сургалт эсвэл нэмэлт боловсрол олгох нь ямар тустай вэ?

Нэмэлт боловсролын хөтөлбөр нь сурагчдад хичээл заах үйл явцад ойлгоогүй ямар ч сэдвээр дэлгэрэнгүй мэдээлэл олгоход туслана эсвэл нөгөө талаас тэдний сонирхол татаж байгаа аливаа сэдвийг нарийвчлан судлах боломжтой болгоно. Хувь хүнтэй ганцаарчилан хичээллэх боломж олгосноор одоо хүртэлх ямар ч сонирхолгүй байсан хичээлдээ сонирхож эхлэх эсвэл асуултуудыг тавих онцгой боломж олгогдоно, одоо хүртэлх үзэх дургүй хичээлдээ сонирхож, үүнд хандах харьцаагаа өөрчлөх боломжтой. Үүний зэрэгцээгээр зарим тохиолдолд нь тэрээр багштайгаа илүү сайн харилцаа тогтоож болно – хичээл заадаг багштай эсвэл бүр гаднаас ирж хичээл заадаг хүнтэй ч гэсэн нөхөрлөг холбоо харилцаа тогтоож болно.

Урт хугацааны үүднээс харж үзэхэд, сурагчийн нэмэлт боловсролд хамрагдах явдал нь түүний ирээдүйн цалин орлогод ч гэсэн эерэгээр нөлөөлөх магадлал өндөртэй байдаг. ЭЗХАХБ-ын тайланд дурдсанаар жил бүр олсон боловсрол нь сурагчдын ирээдүйд авах цалин орлогын хэмжээг дунджаар 7.5-10%-оор нэмэгдүүлдэг. Мөн улсаас боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалт ч гэсэн улсад эргэж буцах болно, учир нь, юу вэ гэхэд, макро эдийн засгийн үүднээс харж үзэхэд, сурагчийн өнөөгийн боловсролын оролцоо ба түүний ирээдүйн сайн сайхан амьдрах нөхцөл нь улс даяар хөдөлмөрийн бүтээмж, ДНБ ба татвар хураалтанд ч гэсэн нь эерэгээр нөлөөлөх болно.

Хичээл давтах сургалттай үндэсний төлөвлөгөө нь ямар онцлогтой ба сонирхолтой байна вэ?

Хичээл давталттай үндэсний төлөвлөгөө нь нэмэлт боловсролын хөтөлбөр болж байгаад, зөвхөн сурагчдын мэдлэгийг өргөжүүлэхэд зориулсан биш, харин илүү өргөн хүрээтэй юм!

- үнэ төлбөргүй (Европын Холбооны "Next Generation EU" гэж нэртэй сангаас авсан санхүүгийн хэрэгслээр төрөөс хариуцдаг),
- сургуулийн удирдлага нь үүнийг зохион байгуулдаг,
- хувь хүний ганцаарчилсан хандлага, жижиг бүлгүүд болон хувь хүн оролцож болно,
- аль хэдийн танигдах багш нар, төдийгүй сургуулийн ажилтнууд зөвхөн биш,
- гэвч ашгийн бус байгууллагуудын мэргэжилтнүүд, их сургуулийн оюутнууд болон бусад хувь хүмүүс оролцож болно, жишээлвэл, эмээ, өвөө зэрэг бусад хүмүүсийн мэдлэгийн эх үүсвэрийг үндэслэлгүйгээр мартагдаж, үл тоомсорлогдож байна;

- хичээллэх цагийн хуваарьт нэмэлт цаг эсвэл үдээс хойшхи дугуйлангийн оронд хичээл давтах хичээл заах болно,
- ихэвчлэн хувь хүнтэй биечлэн суралцах, гэвч үндэслэлтэй тохиолдолд нь сургалтыг онлайнаар хийх боломжтой.
- 2022 оны 1-р сараас эхлэн 2021 оны намрын сургалтыг үргэлжлүүлж байна.
- Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас алсын зайны сургалтанд хамрагдсан сурагчдад зориулж, сургалтын хөтөлбөрийн дутагдлыг нөхөхөд туслах зорилгоор анх бүтээгдсэн. Гэвч зөвхөн "хангалтгүй" үр дүнтэй хүүхэд биш, бараг бүх сурагчид ч гэсэн энэ хөтөлбөрөөс ашиг тус хүртэх боломжтой.
- Энэ хөтөлбөрийн ачаар хүүхдүүд сургууль дээрээ хийж амжаагүй зүйлээ гүйцэхээс гадна ердийн хичээл дээр юу сонирхдог вэ, юм асуух гэхэд цаг дутагдаж байсан бол, одоо дахин асуух боломжтой болно, тэдний сонирхол татаж болох огт мэдээгүй байсан зүйлүүдийг ч гэсэн бас мэддэг болно!

Тайлбарлах үүднээс харж үзэхэд "эцэг эх" ба "сурагч" гэсэн нэр томъёоны дор ерөнхийдөө бусад ямар ч "хууль ёсны төлөөлөгчид" ба "итгэмжлэгч" гэдгийг бодож болно. Мэдээжийн хэрэг насанд хүрсэн сурагчид ба оюутнууд нь асуудалд анхаарлаа хандуулж ойлгож байхад, тэдэнд эцэг эхийн зөвшөөрөл авах шаардлагагүй юм.

[Эцэг эхчүүдэд зориулсан бусад 17 хэл дээрх текстийг /zde/ эндээс татаж болно.](#)